БАТЛАВ:
"БАГАНУУР" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ТҮВШИНЖАРГАЛ

2025 оны 5 -р сарын 22 -ны өдөр

БНХК/20250103037 ДУГААРТАЙ "ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ" ТЕНДЕРИЙН **БАГЦ №1** "КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АУДИТ ХИЙХ, ISO/IEC 27001:2022 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ" ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын зорилго: "Багануур" ХК-ний үйл ажиллагаанд ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог үр дүнтэйгээр нэвтрүүлж үйл ажиллагаандаа бүрэн ашиглахад гол зорилго оршино. Үүнд:

- ✓ Байгууллагын одоогийн Мэдээллийн аюулгүй байдлын зэрэглэлийг тогтоох;
- ✓ Зөрүү шинжилгээ хийх /Gap analysis/;
- ✓ Сүлжээ болон системүүдийн аюулгүй байдлын загварчлал гаргах, зөвлөх;
- ✓ Стандартын шаардлагатай сургалтуудыг хийх, сертификат олгох;
- ✓ Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий мэдлэг олгох сургалтыг бүх ажилтанд хийх;
- ✓ ISO/IEC 27001 стандарт, МАБУТ-ны аудитор бэлтгэх сургалтад 3 ажилтан хамруулах;
- ✓ Баримт бичиг боловсруулахад арга зүйн туслалцаа үзүүлэх;
- ✓ Баталгаажуулалтын аудитад бэлэн болгох;

***Ажил гүйцэтгэх үндэслэл*:** Кибер аюулгүй байдлын тухай хууль

***Ажлын байршил*:** Улаанбаатар хот, Багануур дүүрэг

Гэрээний төрөл: Зөвлөх үйлчилгээ авах

***Захиалагч байгууллага*:** Багануур ХК

Гэрээний үргэлжлэх хугацаа: 8 сар

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа
1	❖ Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, ❖ Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэх	1 сар
	❖ ISO/IEC 27001 стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх • Зөрүүгийн шинжилгээ • Жишиг баримт бичиг, журам • 3 аудитор бэлдэх • Сургалт	6 сар
2	ISO/IEC 27001:2022 стандартын баталгаажуулалтын аудитад бэлэн болгох	1 сар

АЖЛЫН ИЖ БҮРДЭЛ

1.	**Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ** Эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална. ✓ Хараат бус байх ✓ Мэдээллийн нууцлалыг чанд сахих ✓ Ашиг сонирхлын зөрчилгүй байх ✓ Мэргэжлийн байр сууринаас хандах ✓ Нотолгоонд үндэслэсэн байх ✓ Үнэн зөв байх ✓ Хууль, журамд нийцсэн байх /Кибер аюулгүй байдлын тухай хууль, болон бусад хууль, журмууд/ ✓ Захиалагч болон гуравдагч этгээдээс авсан баримт бичгийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хангах ✓ Гүйцэтгэсэн ажлын дүгнэлт, зөвлөмжийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцах ✓ Эрсдэлийн үнэлгээ хийхдээ тухайн системийн тогтвортой, найдвартай, хэвийн ажиллагааг хангаж ажиллах
	Эрсдэлийн үнэлгээний тайланг удирдлагын түвшинд зориулсан хураангуй болон техник багт зориулсан дэлгэрэнгүй тайлан гэсэн 2 төрлөөр хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ. Эрсдэлийн үнэлгээний тайлан нь дараах үндсэн шаардлагыг хангасан байх ✓ Ойлгомжтой, цэгцтэй байх ✓ Товч бөгөөд шаардлагатай гол мэдээллүүдийг агуулсан байх ✓ Эрсдэлийн үнэлгээний үр дүнг бүрэн тусгасан байх ✓ Эрсдэлийг бууруулах зөвлөмжийг тусгасан байх ✓ Тайланг боловсруулсан болон шинэчилсэн огноо, хүний нэр тусгагдсан байх ✓ Тайланд оруулах шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг хавсралтаар оруулах ✓ Тайлан эрсдэлийн үнэлгээ хийсэн хуулийн этгээд болон үйлчлүүлэгч талаар бүрэн хянагдан, зөвшөөрөгдсөн байх Хураангуй тайланд дараах зүйлсийг тусгах ✓ Эрсдэлийн үнэлгээний хугацаа, хийгдсэн өөрчлөлтүүд ✓ Эрсдэлийн үнэлгээний зорилго ✓ Эрсдэлийн үнэлгээний хамрах цар хүрээ ✓ Эрсдэлийн үнэлгээний ерөнхий үр дүнг график, хүснэгт, тоон мэдээллийн үзүүлэлтийг тусгасан байх ✓ Эрсдэлийн үнэлгээний үр дүнд гарсан эрсдэл тус бүрийн жагсаалт Дэлгэрэнгүй тайланд дараах зүйлсийг тусгах ✓ Эрсдэлийн үнэлгээ хийх явц, үр дүнд нөлөөлөхүйц хүчин зүйл, нөхцөл байдал үүссэн эсэх ✓ Эрсдэлийг тэсвэрлэх чадвар ✓ Эрсдэлийн үнэлгээ хийх явцад авсан шаардлагатай шийдвэрүүдийг дурдах ✓ Аудитаар илэрсэн үл тохирлыг арилгах зөвлөмжийг багтаасан аудитын дүгнэлт боловсруулах арга зам, шийдэл ирүүлэх

2.	**Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх**
	Гүйцэтгэх үүрэг ✓ Энтерфрайз архитектур (EA) аудит ✓ МТ тоног төхөөрөмжийн үзлэг шалгалт ✓ Системийн программ хангамжийн үзлэг шалгалт ✓ Өгөгдлийн сангийн үзлэг шалгалт ✓ Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн аудит ✓ Логик ба физик хандалтын аудит ✓ Сүлжээний дэд бүтцийн аюулгүй байдлын аудит (Vulnerability assessment, Penetration test) ✓ Сүлжээний дэд бүтцийн үзлэг шалгалт (Network Assessment) ✓ Мэдээллийн аюулгүй байдлын хяналт, удирдлагын тогтолцоонд буй дутагдлуудаа тодорхойлж засаж, сайжруулах
	Гүйцэтгэгч байгууллага нь доорх жагсаалтын дагуу төлөвлөгөө гарган гүйцэтгэх. ✓ Аудитын хэрэгцээг тодорхойлох ✓ Аудитын зорилго тодорхойлох ✓ Аудитын цар хүрээг тодорхойлох ✓ Үйл ажиллагааг тодорхойлох ✓ Баримт, дата мэдээлэл цуглуулах ✓ Хяналт удирдлагыг шалгах ✓ Асуудлыг илрүүлэх баталгаажуулах ✓ Бичиг баримтжуулах ✓ Тусгай программууд ашиглан эмзэг байдлыг илрүүлэх, хариу арга хэмжээ авах ✓ Тайлангийн шаардлагыг тодорхойлох ✓ Тайлан боловсруулах ✓ Тайланг танилцуулах ✓ Арга хэмжээ авах дээрх үе шатын дагуу гүйцэтгэх ба үе шат болгонд холбогдох тайлан материалуудыг захиалагчид хүргүүлэх
3.	**ISO/IEC 27001 стандарт нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэх**
	✓ Байгууллагын одоогийн мэдээллийн аюулгүй байдлын зэрэглэлийг тогтоох; ✓ Зөрүү шинжилгээ хийх /Gap analysis/ ✓ ISMS (Information Security Management System) тогтолцоог төлөвлөх ✓ Бодлого, журмууд боловсруулж батлуулах ✓ Ажилтнуудад сургалт зохион байгуулах • ISMS-ийн талаарх танилцуулга; • Стандартын шаардлагатай сургалтуудыг хийх, сертификат олгох /Стандарт нэвтрүүлэхтэй холбоотой сургалтын материал, гарын авлагаар хангах/; • Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий мэдлэг олгох сургалтыг бүх ажилтанд хийх; • ISO/IEC 27001 стандарт, МАБУТ-ны аудитор бэлтгэх сургалтад 3 ажилтан хамруулах; ✓ ISMS хэрэгжүүлэлт хийх, баримтжуулах • Боловсруулсан бодлогын баримт бичгийн дагуу хэрэгжилт эхлүүлэх • Шаардлагатай бүртгэл, тэмдэглэлүүдийг бүрдүүлэх ✓ Дотоод аудит, засвар сайжруулалт хийх • ISO 27001 стандартын дагуу дотоод аудит зохион байгуулах • Илэрсэн зөрчлийг засах, баримтжуулах ✓ Баталгаажуулалтын аудитад орох

	• Хөндлөнгийн аудитын өмнөх үзлэг (pre-audit) • ISO/IEC 27001:2022 баталгаажуулалтын аудитын бэлтгэл хангах
4.	**Бусад ажилбар**
	ISO/IEC 27001 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны дотоод аудиторын сургалт мөн тэргүүлэх аудитор бэлтгэх сургалтын төлөвлөгөө ирүүлэх

Боловсруулсан : МТА-ны СЗБ О.Содбилэг

Хянасан : МТА-ны дарга Т.Эрдэнэ-Очир

Танилцсан : XXXX-ийн дарга Д.Хишигдэмбэрэл

БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ТҮВШИНЖАРГАЛ

БНХК/20250103037 ДУГААРТАЙ “ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ” ТЕНДЕРИЙН БАГЦ№2 ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГААГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын нэр: “Багануур” ХК-ийн эзэмшил болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийж гүйцэтгэх

Ажлын байршил: Улаанбаатар хот, Багануур дүүрэг

Гэрээний төрөл: Зөвлөх үйлчилгээ авах

Захиалагч байгууллага: Багануур ХК

Гэрээний үргэлжлэх хугацаа: 3 сар

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Газрын тухай хууль - Засгийн газрын 2024 оны 3-р сарын 06-ны өдрийн 92 дугаар тогтоол “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журам”
2	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Багануур ХК-ийн лицензийн талбай, эзэмшил газрыг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар дүгнэлт, зөвлөмж өгөх, газрын төлөв байдал, чанарыг тогтооход үндсэн суурь мэдээлэл бүрдүүлэх, төлөв байдлыг газар дээр нь судалж, тэдгээрт гарч байгаа өөрчлөлтийг хянан баталгааны ажлын үр дүнгээр тайлбарлан, зураглах. Цаашид тухайн газрын оновчтой, үр ашигтай эзэмших, ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тавих нөхцлийг бүрлүүлэхэд оршино.
3	Хамрах хүрээ	Багануур ХК-ийн эзэмшил болон тусгай зөвшөөрөлтэй талбай. Үүнд: 1. Уурхайн 4 тусгай зөвшөөрөл бүхий олборлолтын талбай нийт 5963.64 га 2. Уул уурхайн олборлолт, үйлдвэрлэлийн барилг байгууламж, хоккей, спорт цогцолбор, тэсрэх материалын агуулах, амины болон нийтийн орон сууцны зориулалттай 10 нэгж талбайн нийт 3640.4 га
4	Ажлын иж	*1. Бэлтгэл ажлын үе шат*

	бүрдэл /хийгдэх ажлууд/	Өмнө хийгдсэн хөрс, ургамал, газар ашиглалт, гадаргын төлөв байдлын онцлогтой холбогдох судалгаа, шинжилгээний материалтай танилцах, хянан баталгаа хийх нэгж талбаруудыг тогтоох, хил заагийг тодруулах, ажиглалт хэмжилт хийх цэгүүдийг урьдчилан тогтоох, ажлын зураг бэлтгэх зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Үүнд: а. Зохих нарийвчлал хангасан хиймэл дагуулын зургийн боловсруулалт хийх б.Ажлын зураг бэлтгэх *2. Талбай буюу хээрийн судалгааны ажлын үе шат* • Хөрс • Ургамал • Газрын гадарга, түүний хэвлий Нэгж талбар бүрийн төлөв байдал, түүний өөрчлөлтийг газар дээр нь судлан тогтоож зураглан, лабораторийн шинжилгээнд дээж авна. *3. Материал боловсруулалтын ажлын үе шат* Хээрийн ажиглалт, хэмжилт, лабораторийн задлан шинжилгээний дүнг нэгтгэн газрын төлөв байдалд дүгнэлт өгнө. *4. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай тус бүрээр тайлан боловсруулна.* *5. Захиалагчийн техникийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар /ГЗБГЗЗГ/ хийлгэнэ.* *6. Ажлын эцсийн үр дүнд Улсын хянан баталгааны Ерөнхий шинжээчийн дүгнэлт гаргуулна.*
5	Бүтээгдэхүүн	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журамд заасан хянан баталгааны үр дүн нь дараахь баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд: 1. Төлөв байдлын тодорхойлолт, лабораторийн шинжилгээний дүн 2. Газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтийн паспорт 3. Мэргэжлийн байгууллагын хянан баталгааны дүгнэлт 4. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургууд, түүний CD дээр хуулсан файл; 5. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийсэн тухай тайлан, зургийн тайлбар бичиг эх хувиар
6	Тайлагнах	Ажлын даалгаварт тусгасан ажлын нэгтгэсэн тайланг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай тус бүрээр 2 хувь, Улсын хянан баталгааны Ерөнхий шинжээчийн дүгнэлтийг тус бүр 1 хувь цаасан болон электрон хэлбэрээр хүлээлгэн өгнө.

Хянасан: Танилцсан: ХАБЭАБОХХ-ийн дарга Ч.Ариунбаатар

Боловсруулсан: Байгаль орчны мэргэжилтэн О.Мөнхуяа

БАТЛАВ.
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ТҮВШИНЖАРГАЛ

БНХК/20250103037 ДУГААРТАЙ “АУДИТЫН ШАЛГАЛТ” ТЕНДЕРИЙН
БАГЦ№3 БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ажлын нэр: “Багануур” ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийж гүйцэтгэх

Ажлын байршил: Улаанбаатар хот, Багануур дүүрэг

Гэрээний төрөл: Зөвлөх үйлчилгээ авах

Захиалагч байгууллага: Багануур ХК

Гэрээний үргэлжлэх хугацаа: 2 сар

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1	Ажил гүйцэтгэх үндэслэл	- Байгаль орчны тухай хууль - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/809 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны аудит хийх ерөнхий аргачлал”
2	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Багануур ХК-ийн хүрэн нүүрсний ордыг ашиглах үйл ажиллагаанд байгаль орчны холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг шалган, үнэлгээ, дүгнэлт өгөх, илэрсэн үл нийцлийг арилгах арга хэмжээний зөвлөмж боловсруулахад аудитын зорилго оршино. *Байгаль орчны сөрөг нөлөөлөл, орхигдлыг илрүүлж, цаашид авах арга хэмжээг төлөвлөх, зөвлөмж боловсруулах, аудитын дүгнэлт гаргах*
3	Хамрах хүрээ	Багануур ХК-ийн хүрэн нүүрсний ордыг ашиглах үйл ажиллагаанд
4	Ажлын иж бүрдэл /хийгдэх ажлууд/	1. Байгаль орчны аудитыг байгаль орчин, удирдлагын тогтолцоо, газар ашиглалт, хөрс хамгаалал, агаарын чанар, ургамлан нөмрөг, ус ашиглалт, хатуу болон шингэн хаягдал, химийн хортой болон аюултай бодис, цацрагийн эх үүсвэр, биологийн төрөл зүйлийн олон янз байдал, орон нутгийн оролцоог хангах гэсэн үндсэн чиглэлүүдийн хүрээнд аудитын ажлыг гүйцэтгэж, компанийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлтийг гаргах, одоо байгаа нөхцөл, төлөв байдал, цаашид үүсэх эрсдлүүд зэрэгт тулгуурлан богино болон урт хугацааны

		туршид авч хэрэгжүүлэх /сэргийлэх, бууруулах, арилгах гэх мэт/ арга хэмжээний зөвлөмжийг улсын болон олон улсын туршлагад үндэслэн нарийн нягт гаргах 2. Байгаль орчинтой холбоотой хууль тогтоомж, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний хэрэгжилтийг тодорхойлох 3. Монгол улсын болон олон улсын байгаль орчны стандартын тохирол, байгаль орчны менежментийн төлөвлөгөө тайлангийн хэрэгжилт болон өмнө хийгдсэн байгаль орчны аудитын зөвлөмжийн мөрөөр гүйцэтгэсэн ажлын төлөвлөгөө, тайлангийн хэрэгжилтэнд дүгшнэлт хийх, зөвлөмж өгөх
5	Бүтээгдэхүүн	Байгаль орчны аудитын үр дүн нь дараахь баримт бичгүүдээс бүрдэнэ. Үүнд: 1. Байгаль орчны аудитын тайлан эх хувиар 2% 2. Тайлангийн CD дээр хуулсан файл;
6	Тайлагнах	Ажлын даалгаварт тусгасан ажлын нэгтгэсэн тайланг эх хувиар 2 хувь, цаасан болон электрон хэлбэрээр хүлээлгэн өгнө.

Хянасан: Танилцсан: ХАБЭАБОХХ-ийн дарга Ч.Ариунбаатар

Боловсруулсан: Байгаль орчны мэргэжилтэн О.Мөнхуяа